


БАТЛАВ:
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
 /Д. БАТСАЙХАН/
2019 оны 05-р сарын 27

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР
НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019 оны 05-р сарын 27

Наранбулаг

Энэхүү гэрээг нэг талаас Увс аймгийн Наранбулаг сумын Засаг дарга Ц.Загдсамбар (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас Хараганатын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эй Эл Жи Ти" ХХК-ийг төлөөлж ерөнхий захирал Тохтасынов Т.М. (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2019 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Увс аймгийн Наранбулаг сумд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Увс аймгийн Наранбулаг сум болон Алдар багийн нутагт Гурван толгой нэртэй газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын харилцааг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

1.2. Дээрх тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Монгол улсад мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй болно.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохиж хариуг өгөх;

2.1.7. Экспортод гарах бүтээгдэхүүн (хүдэр)-ий тээвэрлэлтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, үүнтэй холбогдон үүсэх асуудлыг төрийн болон орон нутгийн байгууллагуудаар шийдвэрлүүлэхэд туслалцаа үзүүлэх.

2.1.8. Харганат – Мянгад (Ховд аймаг) чиглэлийн замыг Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүч бололцоогоор засварлах үед орон нутгийн барилгын материалыг (хайрга, дайрга) авахад хууль журмын хүрээнд дэмжлэг үзүүлэх.

2.1.9. Байгаль орчныг хамгаалах, мөн тээвэрлүүлж буй бүтээгдэхүүний 1 тоннд ногдох тоосны хэмжээг бууруулахын тулд тухайн сумуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх шороон зам дээр хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвшөөрөх. Тээврийн хэрэгслийн даацын хувьд нүүрс, барилгын материал болон бусад барааг тээвэрлэдэг бусад хуулийн этгээд, хувь хүмүүсийн адил тэгш, үл ялгаварлан гадуурхах нөхцөлийг хангах.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Нийт ажлын байрны 50-иас доошгүй хувьд тухайн орон нутгийн мэргэжлийн шаардлагад нийцэх иргэдийг ажиллуулах;

3.1.5. Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд Засаг даргад мэдэгдэх;

3.1.6. Хуулийн дагуу томилогдсон орон нутгийн төлөөлөгч (компанийн ажилтан)-өөр дамжуулан хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон компанийн үйл ажиллагааны талаар тухайн сумын иргэдэд ил тод нээлттэй мэдээлэл өгч байх;

3.1.7. Компани нь тухайн онд гагцхүү Хамтын ажиллагааны хорооны бүх гишүүдийн хурлын тогтоол, протоколоор батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана;

3.1.8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа явуулдаг татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд ижил нөхцөл санал болгосон тохиолдолд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.9. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.10. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр сумд техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон сумын иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг компанитай зөвшилцөн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хамтын ажиллагааны хороо дараа онд хэрэгжүүлэх төслийн дүн, төрлийг 12-р сарын 31-ээс өмнө тогтооно.

Тав. Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлнэ. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэнэ. Сайлшгүй тохиолдолд гэрээний хувийг орос хэл дээр үйлдэж болно.


Хамтын ажиллагааны хорооны бүх гишүүдийн 2019 оны 04-р сарын 27-ны өдрийн ... тоот хурлын тогтоолыг хавсаргав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАГ:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН

ЗАСАГ ДАРГА




(Ц.ЗАГДСАМБАР)

АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ,

“ЭЙ ЭЛ ЖИГИ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ

ЗАХИРАГ



(ТОХТАСЫНОВ Т.М.)

**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХҮҮРЭЭНД 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх талууд	Үр дүн	Санхүүжүүлэгч тал	Төсөв/ зардал	Хэрэгжих цаг, хугацаа
1	Бургастайн усны цөөрөм	ЗДТГ	Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариадан гэсэн 4 сумын бэлчээрийн доройтлоос хамгаална, мал маллах, тариалангийн талбай услах, мөн үндны усны хэрэглээ хангагдана.	«Эй Эл Жи Ти» ХХК	Тооцооны дагуу олгоно	2019 онд багтааж дуусгана
2	Алдар багийн конторын барилга /хурлын зал, эмчийн өрөө, ЗД-ын өрөө, хашаа+тохижилт/	ЗДТГ	Багийн ард иргэдэд мэдээлэл авах, хурал хийх, үзвэр үзэх тохилог орчин бий болно.	«Эй Эл Жи Ти» ХХК	25,0 сая	
3	Лаборатори – биохимийн шинжилгээний аппарат	ЗДТГ	Өвчнөөс урьдчилан сэргийлэх	«Эй Эл Жи Ти» ХХК	20,0 сая	
Бүтд						

Жиш: Хүснэгтэд харуулсан төлөвлөгөөт арга хэмжээнээс гадна уул уурхайн чиглэлээр суралцаж, цаашид “Эй Эл Жи Ти” ХХК-ид ажиллах онд сурлагтай 2 хүүхдэд нийт 6 сая төгрөгийн хандивыг олгонос.